



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ” ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/37/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор С.Алтанхуяг
Утас: 260512 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди Аудит ХХК
Захирал: Д.Эхбаяр
Утас: 7000 6948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

Аудитын Санал Дүгнэлт.....	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Материаллаг байдал.....	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
8. Аудитын илрүүлэлт.....	15
8.1 Төлбөрийн акт.....	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/542
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь аймгууд дахь харьяа газруудын технологийн үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулж, захирлын тушаалаар батлуулсан байна. Түүнчлэн дамжуулах байгууламж болон гадаад байгууламжийн эзлэх хувийг аймаг бүрээр гаргаж, аймгуудад зэрэглэл тогтоож хасах үзүүлэлтийг шинэчилсэн байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК тайлант онд нийт 51,719.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 51,019.4 сая төгрөгийн зардал гарган, 700.3 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 53,702.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 52,423.6 сая төгрөгийн зардал гаргаж, 1,278.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Бусад асуудал

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2021 онд "Монголын хөгжлийн сүлжээ" дунд хугацаа нь зорилго, зорилтуудыг биелүүлэх, түүнтэй уялдуулан сумдын түвшний сүлжээг өргөтгөж үндсэн сүлжээний урсгал түгээх үйл ажиллагааг бүрэн шинэчлэх, гадаад, дотоодын үүсвэрээр алслагдсан сум, суурин газруудыг шилэн кабелийн сүлжээнд холбох, технологийн байр, цамхаг, нөөц тэжээлийг шинэчлэн сайжруулах, зорилтуудыг дэвшүүлэн бүрэн хэрэгжүүлэн ажилласан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,956,409,038.80	6,868,246,159.95
1.1.2	Дансны авлага	4,778,655,133.33	5,464,427,367.91
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	434,401,591.14	670,164,470.38
1.1.4	Бусад авлага	25,139,587.86	358,043,058.43
1.1.6	Бараа материал	4,213,289,748.55	4,796,039,596.87
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	853,623,469.06	853,369,349.09
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	16,261,518,568.74	19,010,290,002.63
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	129,175,231,067.75	122,772,609,627.63
1.2.2	Биет бус хөрөнгө	38,094,035,988.52	37,824,653,147.48
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	769,308,384.76	1,166,816,505.43
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	4,992,898,691.59	4,992,898,691.59
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	173,031,474,132.62	166,756,977,972.13
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	189,292,992,701.36	185,767,267,974.76
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,006,542,387.63	852,317,195.31
2.1.1.2	Цалингийн өглөг	175,592,753.72	-
2.1.1.3	Татварын өр	8,735,597.95	
2.1.1.4	НДШ - ийн өглөг	913,096.80	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	159,931,910.83	17,270,741.19
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	721,589,785.89	771,442,646.94
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,073,305,532.82	1,641,030,583.44
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	40,370,359,367.99	38,233,402,747.30
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	3,283,298,042.98	3,490,670,220.14
2.1.2.5	Хойшлогдсон орлого	41,862,139,189.87	39,619,349,982.25
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	85,515,796,600.84	81,343,422,949.69
2.2	Өр төлбөрийн нийт дүн	87,589,102,133.66	82,984,453,533.13
2.3.1	Өмч: - төрийн	137,551,494,711.54	137,551,494,711.54
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,216,140,727.72	16,116,558,631.08
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	41,875,174,300.83	42,047,596,216.11
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(93,938,919,172.39)	(92,932,835,117.10)
2.3.11	Эздийн өмчийн дүн	101,703,890,567.70	102,782,814,441.63
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	189,292,992,701.36	185,767,267,974.76

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	49,346,745,333.65	51,487,449,751.40
2	Борлуулалтын өртөг	46,043,080,625.07	47,500,384,920.33
3	Нийт ашиг (алдагдал)	3,303,664,708.58	3,987,064,831.07
5	Хүүний орлого	272,986,167.91	147,757,016.25
8	Бусад орлого	2,076,881,322.06	2,063,463,785.13
9	Борлуулалт, маркетингийн зардал	361,700,547.01	434,313,880.90
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,248,068,801.58	3,307,691,611.37
12	Бусад зардал	1,219,893,796.97	1,119,563,005.88
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	22,330,004.39	(6,594,999.39)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	781,272.73	(51,541,888.64)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	846,980,330.11	1,278,580,246.27
19	Орлогын татварын зардал	29,114,023.19	132,822,637.01
19.1	Хойшлогдсон татварын зардал	223,960,932.92	189,747,594.41
20	Татварын дараах ашиг (алдагдал)	593,905,374.00	956,010,014.85
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	593,905,374.00	956,010,014.85
24	Орлогын нийт дүн	593,905,374.00	956,010,014.85

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	137,551,494,711.54	16,216,140,727.72	42,041,126,681.79	(94,464,245,981.59)	101,344,516,139.46
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	2,161,435.20	2,161,435.20
3	Залруулсан үлдэгдэл	137,551,494,711.54	16,216,140,727.72	42,041,126,681.79	(94,462,084,546.39)	101,346,677,574.66
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	593,905,374.00	593,905,374.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(165,952,380.96)	-	(165,952,380.96)
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	(70,740,000.00)	(70,740,000.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	137,551,494,711.54	16,216,140,727.72	41,875,174,300.83	(93,938,919,172.39)	101,703,890,567.70
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	9,882,483.80	9,882,483.80
11	Залруулсан үлдэгдэл	137,551,494,711.54	16,216,140,727.72	41,875,174,300.83	(93,929,036,688.59)	101,713,773,051.50
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	956,010,014.85	956,010,014.85
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	172,421,915.28	-	172,421,915.28
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(59,390,540.00)	(59,390,540.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(99,582,096.64)	-	99,582,096.64	-
17	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	137,551,494,711.54	16,116,558,631.08	42,047,596,216.11	(92,932,835,117.10)	102,782,814,441.63

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	54,453,590,200.00	52,267,979,695.63
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	51,692,271,617.14	51,994,363,281.88
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	34,732,854.26	17,301,261.11
	Бусад мөнгөн орлого	2,726,585,728.60	256,315,152.64
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	43,683,525,073.44	44,538,594,005.13
	Ажиллагчдад төлсөн	14,357,185,422.14	15,206,176,902.62
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,377,748,822.42	4,678,266,695.91
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,810,865,571.57	1,960,680,105.95
	Ашиглалтын зардалд төлсөн	11,945,558,419.34	12,636,376,536.95
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,388,231,957.24	1,710,370,662.99
	Хүүний төлбөрт төлсөн	1,581,425,190.19	906,827,167.90
	Татварын байгууллагад төлсөн	6,075,650,304.29	6,205,824,615.90
	Даатгалын төлбөрт төлсөн	65,081,530.00	53,291,277.00
	Бусад мөнгөн зарлага	1,081,777,856.25	1,180,780,039.91
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,770,065,126.56	7,729,385,690.50
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	407,146,732.29	147,828,516.25
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	804,400.00	71,500.00
	Хүлээн авсан хүүгийн орлого	406,342,332.29	147,757,016.25
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,545,242,046.60	4,767,295,273.90
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,973,186,771.60	4,522,610,156.90
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	572,055,275.00	244,685,117.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,138,095,314.31)	(4,619,466,757.65)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	32,737,843.07	203,027.83
	Бусад	32,737,843.07	203,027.83
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,604,726,555.03	2,198,284,839.53
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,532,046,612.21	2,136,956,620.93
	Төлсөн ногдол ашиг	70,740,000.00	59,390,540.00
	Бусад	1,939,942.82	1,937,678.60
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,571,988,711.96)	(2,198,081,811.70)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,059,981,100.29	911,837,121.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,896,427,938.51	5,956,409,038.80
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,956,409,038.80	6,868,246,159.95

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
А	Нийт орлого	сая.төг	51,746.20	51,719.70	53,702.20	1,982.60	103.8
	Үүнээс: Үндсэн сүлжээний борлуулалт	сая.төг	48,357.20	48,469.60	50,589.20	2,119.70	104.4
Б	Нийт зардал	сая.төг	50,899.20	51,019.40	52,423.60	1,404.20	102.8
	Үүнээс: Удирдлагын зардал	сая төг	827.3	834.8	827.9	-6.9	99.2
	Элэгдлийн зардал	сая төг	12,153.40	12,864.90	12,228.00	-636.9	95
В	Үйл ажиллагааны бодит ашиг /ЕБИТДА/	сая төг	11,919.50	12,431.80	12,386.10	-45.7	99.6
	Татварын өмнөх ашиг/алдагдал	сая.төг	847	700.2	1,278.60	578.4	182.6
	Орлогын албан татвар	сая.төг	253.1	316.8	322.6	5.8	101.8
	Цэвэр ашиг	сая.төг	593.9	383.4	956	572.6	249.3
	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	төг	1	1	1	-	99
	Нийт авлага	сая.төг	4,803.80	5,109.20	5,464.40	355.3	107
	Нийт өр төлбөр	сая.төг	45,727.00	42,235.30	43,365.10	1,129.80	102.7
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая төг	2,073.30	774	1,641.00	867	212
	Цалингийн сан	сая төг	14,451.70	15,338.70	15,124.60	-214.1	98.6
	Нийт ажиллагсдын тоо	хүн	1,325.00	1,346.00	1,326.00	-20	98.5
	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	908.9	949.6	950.5	0.9	100.1
	Хөрөнгө оруулалт	сая төг	6,795.30	7,475.60	3,827.60	-3,648.00	51.2
	Зээлийн төлбөр	сая төг	2,125.20	2,125.20	2,137.00	11.8	100.6
	Сүлжээний бэлэн байдлын үзүүлэлт	хувь	100	99.9	100	0.1	100.1
	Төсвийн нийт төлбөр	сая төг	10,524.10	10,138.70	10,943.50	804.7	107.9
	Үүнээс: Ногдол ашиг	сая төг	70.7	55.2	59.4	4.2	107.5

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, бодлого үйл ажиллагаа, дотоод хяналттай холбоотой асуудлуудын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 12-ны хооронд эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн аудитын менежер Д.Насанжаргал, ахлах аудитор О.Алтанцэцэг, М.Нурболат, Д.Жаргалсайхан, аудитор О.Ганчимэг, аудитын шинжээч Ч.Ням-Очир нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Оюунцэцэг, захирал Д.Эхбаяр нар хэрэгжүүлсэн.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар (Эс Жи Эм Ди Аудит ХХК)-т 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 01/111 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Аймаг орон нутаг, Улаанбаатар төвийн салбарууд касс, дараа тайлангийн баримтыг боловсруулах нэгдсэн аргачлалгүй, өөр өөр зарчмаар гүйцэтгэж байна. Салбаруудын мөнгөн хөрөнгийн тайлан гаргах, дэмжих баримтуудын гүйцэтгэлийг нэг хэлбэрт оруулж тайлагнадаг байдлыг НББ баримт бичигт тодорхой заах шаардлагатай байна.

Дотоод хяналтын алба нь 2021 онд “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн газар, хэлтсүүдийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдлийг тодорхойлох, бууруулах чиглэлээр албан даалгавар, зөвлөмж өгч, гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр ханган, шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилт тавьж ажиллалаа. 2021 онд Улаанбаатар хотын сүлжээний газар, Хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Борлуулалтын хэлтэс, Төв, Хөвсгөл, Завхан, Архангай, Увс, Ховд, Баян-Өлгий, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн газар зэрэг 13 газар, нэгжийг хяналт, шинжилгээ үнэлгээнд хамруулан хяналт шалгалт хийсэн байна.

Хяналт шалгалтаар *Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилт*, 2020-2021 оны зорилтот түвшний төлөвлөгөөний биелэлт, Шилэн дансны цахим системийн хөтлөлт, болон бусад холбогдох хууль, журмын хэрэгжитэнд хяналт, үнэлгээ хийж гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогын 49,346.4 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 986.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 789.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн зорилго нь Монгол Улсыг мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, салбарын хуулийн этгээдүүдэд ижил тэгш нөхцлөөр үйлчлэх, төсвийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, өөрийгөө бүрэн санхүүжүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг урсгалын түрээс, байр цамхагийн түрээс, холбооны ашиглалт үйлчилгээ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ХХК гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 100 хувь эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2006 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 491 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ

талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолын заалттай нийцэж байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу ажилласан байна. Тухайлбал 2 нэр төрлийн 146.4 сая төгрөгийн барилга засвар, программ хангамж худалдан авалтыг зохион байгуулахгүй хэмнэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль
- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал “Журам шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаал “Журам батлах тухай”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,956,409.0	6,868,246.2	911,837.2
Авлага	5,238,196.3	6,492,635.0	1,254,438.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	4,213,289.7	4,796,039.6	582,749.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	853,623.5	853,369.3	(254.2)
Үндсэн хөрөнгө	129,175,231.1	122,772,609.6	(6,402,621.5)
Биет бус хөрөнгө	38,094,036.0	37,824,653.1	(269,382.9)
Хойшлогдсон татварын хөрөнгө	769,308.4	1,166,816.5	399,508.1
Бусад эргэлтийн бус хөрөнгө	4,992,898.7	4,992,898.7	-
Нийт хөрөнгийн дүн	189,292,992.7	185,767,268.0	(3,525,724.7)
Өр төлбөрийн дүн	87,589,102.1	82,984,453.5	(4,604,648.6)
Богино хугацаат өглөг	2,073,305.5	1,641,030.6	(432,274.9)
Урт хугацаат өглөг	85,515,796.6	81,343,422.9	(4,172,373.7)
Эздийн өмч	101,703,890.6	102,782,814.4	1,078,923.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	189,292,992.7	185,767,268.0	(3,525,724.7)

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 16.1 сая төгрөг болж өмнөх оноос 5.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Банк дахь харилцах дансанд 6,852.1 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд дансны авлага 5,464.4 сая, ААНОАТ-ын авлага 85.8 сая, НӨАТ-ын авлага 559.9 сая, НДШ-ийн авлага 10.1 сая, ХХОАТ-ын авлага 9.5 сая, бусад татварын авлага 4.9 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд үүссэн байгууллагаас авах авлага болон бусад авлага 1,018.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 5,616.3 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 44.3 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг авлагын хувийн жингийн аргаар тооцдог байна. Тайлант онд 44.7 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, найдваргүй авлагыг данснаас хассан шийдвэр гаргаагүй байна.

Тайлант онд гэрээт ажлын төлбөрт 758.0 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2019-2020 онд шилжүүлсэн 95.3 сая төгрөгийн ажил гэрээний хугацаа дуусаагүй шалтгаанаас дуусаагүй, гүйцэтгэлийг хүлээн аваагүй байна. Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 758.3 сая төгрөгийг дансанд шилжүүлэн бүртгэсэн/ зардалд хүлээн зөвшөөрсөн/ байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,796.0 сая төгрөг болж 582.7 сая төгрөгөөр өссөн хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатахууны үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 1,960.7 сая төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд, бусдаас үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 44.3 сая төгрөгийн бараа материал байна. Энэ нь бичиг хэргийн материал, хангамжийн материал, хөдөлмөр хамгаалалын хувцас байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд өөрчлөлт орсон нь дараах шалтгаантай байна. Үүнд: Шинээр 5,106.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 11 сарын 29-ний А-1/1947 тоот тогтоолоор нийт 391.7 сая төгрөгийн өртөгтэй, 391.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 585 ширхэг хөрөнгө, ТӨБЗГ-ын 2021 оны 12 сарын 02-ны өдрийн 592 тоот тогтоолоор 5,063.3 сая төгрөгний өртөгтэй, 4,970.4 сая төгрөгний хуримтлагдсан элэгдэлтэй 726 ширхэг хөрөнгийг тус тус акталж, ТӨБЗГ-ын 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн А-5/2296 тоот тогтоолоор 200 сая төгрөгийн өртөгтэй, ТӨБЗГ-ын 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 81 тоот тогтоолоор 42.2 сая төгрөгийн өртөгтэй тус тус шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2021 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 90 тоот тогтоолоор 122.9 сая төгрөгний анхны өртөгтэй 108.9 сая төгрөгний хуримтлагдсан элэгдэлтэй нийт 2 ширхэг хөрөнгийг төрийн өмчит байгууллагуудад балансаас баланст шилжүүлжээ.

Биет бус хөрөнгө 349.4 сая төгрөгөөр өссөн нь шинээр худалдаж авсан лиценз, тусгай зөвшөөрөл байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгөнд 4,992.8 сая төгрөгийн сумдын түвшний сүлжээ, хөрөнгө солилцооны авлагыг бүртгэсэн.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,641.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 432.2 сая төгрөгөөр буурсан нь гадаад сувгийн төлбөр, цалингийн өглөгийг төлсөнтэй холбоотой байна. Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 81,343.42 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4,172.3 сая төгрөгөөр буурсан нь Сангийн яамтай байгуулсан гэрээний дагуу Дамжуулан зээлдүүлэх зээлийн зээл, зээлийн хүүг хугацаанд нь төлж байгаатай холбоотой байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 1,404.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь захиалгат ажлын хэмжээ болон шатахуун, түлшний үнэ нэмэгдсэн зэргээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 638 дугаар тогтоолоор Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 51,719.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 51,019.4 сая төгрөгөөр, 700.3 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 6,622.4 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 302 дугаар тогтоолоор Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 853.2 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 53,702.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 52,423.6 сая төгрөгийн зардал гарган, 1,278.5 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 53,702.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,982.5 сая төгрөг буюу 103.8 хувиар давсан үндсэн сүлжээний борлуулалтын хэмжээ өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 1,404.2 сая төгрөг буюу 102.7 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь үйл ажиллагааны зардал нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

2021 оны хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 31 нэр төрлийн хөрөнгө оруулалтын ажилд өөрийн эх үүсвэрээс 4,750.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 956.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 255.7 сая төгрөгөөр илүү буюу 136.5 хувиар давж биелсэн бөгөөд үүнд орлогын хэмжээг өндөр дүнгээр нэмэгдүүлсэн нь нөлөөлж байна.

Тайлант онд тухайн байгууллагын хөрөнгөөр яам, агентлаг, төсөвт байгууллага/-д хөрөнгө бэлтгэж, төсвөөс гадуур зардал гараагүй байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 228 дугаар тогтоолын дагуу тайлант онд 59.4 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна. Мөн түрээсийн төлбөрийн 40 хувь болох 150.0 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК нь тайлант онд нийт 6,812.6 сая төгрөгийн 256 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,444.0 сая төгрөгийн 1 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1,793.8 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаанд мөрдөж ажиллах шаардлагатай байна. Тайлант онд Сумдын өгөгдлийн сүлжээний өргөтгөлийн төхөөрөмж нийлүүлэх” МХС/202101012 тоот тендерээр худалдан авсан 311.0 сая төгрөгийн үнэ бүхий 110 ширхэг тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг буруу /алдаатай/ гаргаснаас нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийн ажиллагааг дахин тохируулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 “Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.”, 46 дугаар зүйлийн 46.1.4 “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;”, 46.1.6 “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим

системд оруулах;” 47 дугаар зүйлийн 47.2.1 “техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

2. Сервер болон хадгалах төхөөрөмж нийлүүлэх 325.9 сая төгрөгийн МХС/202101010 тоот тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй тендерийн хүчинтэй хугацаа дууссаны дараа гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 “Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 30 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна.”, 29 дугаар зүйлийн 29.2 “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.” 29.4 “Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах боломжгүй болсон бол захиалагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган, зөвшөөрөл авсны үндсэн дээр уг хугацааг нэг удаа 15 хоногоор сунгаж болно” заалтыг хэрэгжүүлж ажиллагаагүй, тохиолдсон байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлсэн,

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлтэй тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 995.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 669.1 сая төгрөгийн 4 зөрчлийг арилгасан, 326.5. сая төгрөгийн алдаа, 2 зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 574.3 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 1.1 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс албан шаардлага 60 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	574.3	3	574.3	2	-	60
Зөвлөмж	3	1.1	3	1.1	-	-	100
Нийт дүн	8	575.4	6	575.4	2	-	80

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдан авалт болон аймгууд дах салбаруудад хийх аудитыг дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 49.2 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 48.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 49.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 789.5 сая төгрөгийн түвшинээс 740.3 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

“Хөргөлтийн тоног төхөөрөмж нийлүүлэх” МХС/202101025 тоот тендерт шалгарсан Синус Дочи ХХК-ийн тендерт ирүүлсэн үнийн санал нь арифметик алдаатай бөгөөд зөрүү нь 0.6 сая төгрөг байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.1 “тендерийн үнэд арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, захиалагч энэ хуульд заасныг үндэслэн үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно;” заалтыг хэрэгжүүлж ажиллагаагүй, тохиолдсон байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов,

8.3 Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт:

Жилийн эцсийн байдлаар 2 нэр төрлийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг (4.3) сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна. Өөрөөр хэлбэл элэгдлийн зардал илүү бодогдсон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн “20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлан жилийн эцэст 2 нэр төрлийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг зөв бүртгэх, НББОУС-16 хэрэгжүүлж ажиллах,

2. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт:

Компани бараа материалын насжилтын тайлан бэлдээгүй, бараа материалын үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг тестлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн “20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын насжилтийн тайланг бэлтгэх, тайлант хугацааны эцэст үнэ цэнийн бууралтыг шалгаж байх, НББОУС-2 хэрэгжүүлж ажиллах,

3. Дотоод хяналттай холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт:

Аймаг орон нутаг, Улаанбаатар төвийн салбарууд касс, дараа тайлангийн баримтыг боловсруулах нэгдсэн аргачлалгүй, өөр өөр зарчмаар гүйцэтгэж байна. Төвийн кассын орлого зарлагын баримтанд гүйцэтгэлийн баримтыг хавсаргадаггүй, баримтыг дараа тайлан тооцоо дансны баримтанд хавсаргаж байна. Төв болон салбаруудын мөнгөн хөрөнгийн тайлан гаргах, дэмжих баримтуудын гүйцэтгэлийг нэг хэлбэрт оруулж тайлагнадаг байдлыг НББ баримт бичигт тодорхой заах шаардлагатай. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дараа тайлангийн баримтыг нэгдсэн нэг аргачлалаар боловсруулж, бүх салбарт мөрдүүлж ажиллах, НББОУС-1 хэрэгжүүлж ажиллах,

4. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал:

4.1 Илрүүлэлт:

Компани дансны авлагын насжилтын тайлан гаргадаг, бүрэн бэлдээгүй. Өөрөөр хэлбэл хэвийн авлагыг тусад нь харуулаагүй бөгөөд авлага үүссэн өдрөөс насжилтын хугацааг тоолж байгаа нь НБББББ-т заасны дагуу Найдваргүй авлагын нөөцийг тооцож бүртгээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” “20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дансны авлагын насжилтын тайланг бэлтгэхдээ насжилтын хугацааг зөв тооцох, найдваргүй авлагын нөөцийг НБББББ-т заасны дагуу тооцож бүртгэх,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					Залруул га		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж			
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	АХГ-2022/37/НА-СТА-ТӨА	"Хөргөлтийн тоног төхөөрөмж нийлүүлэх" МХС/202101025 тоот тендерт шалгарсан Синус Дочи ХХК-ийн тендерт ирүүлсэн үнийн санал нь арифметик алдаатай бөгөөд зөрүү нь 650,0 мянган төгрөг байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрүү 0.6 сая төгрөгт төлбөрийн акт тогтоох	1	650.0	-	-	1	650.0	-	-	-	-	-	
3	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	АХГ-2022/37/НА-СТА-ТӨА	Жилийн эцсийн байдлаар 2 нэр төрлийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг (4,277.3) мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна. Өөрөөр хэлбэл элэгдлийн зардал илүү бодогдсон.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-16 хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	4,277.3	-	-	-	-	-	-	-	-	1	4,277.3
4	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	АХГ-2022/37/НА-СТА-ТӨА	Компани бараа материалын насжилтын тайлан бэлдээгүй, бараа материалын үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг тестлээгүй.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-2 хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	44,314.7	-	-	-	-	-	-	-	-	1	44,314.7
5	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	АХГ-2022/37/НА-СТА-ТӨА	Аймаг орон нутаг, Улаанбаатар төвийн салбарууд касс, дараа тайлангийн баримтыг боловсруулах нэгдсэн аргачлалгүй, өөр өөр зарчмаар гүйцэтгэж байна. Төвийн кассын орлого зарлагын баримтанд гүйцэтгэлийн баримтыг хавсаргадаггүй, баримтыг дараа тайлан тооцоо дансны баримтанд хавсаргаж байна. Төв болон салбаруудын мөнгөн хөрөнгийн тайлан гаргах, дэмжих баримтуудын гүйцэтгэлийг нэг хэлбэрт оруулж тайлагнадаг байдлыг НББ баримт бичигт тодорхой заах шаардлагатай.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-1 хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
6	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	АХГ-2022/37/НА-СТА-ТӨА	Компани дансны авлагын насжилтын тайлан гаргадаг боловч үнэн зөв бэлдээгүй. Өөрөөр хэлбэл хэвийн авлагыг тусад нь харуулаагүй бөгөөд авлага үүссэн өдрөөс насжилтын хугацааг тооллосон.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-1 хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
ДҮН					5	49,242.0	-	-	1	650.0	-	-	-	-	4	48,592.0

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
1	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	АХГ-2022/37/НА-СТА-ТӨА	Тайлант онд шилэн дансны “хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)” хэсэгт мэдээлэх 1,793.4 сая төгрөгийн 8 тендерийн ерөнхий мэдээлэлийг хугацаа хоцроож оруулсан. “Жи-Мобайл” ХХК-аас авах авлагад тооцон 1,444.0 сая төгрөгийн үнэ бүхий 177 км урттай газрын шилэн кабелийг ТӨБЗГ-ын 2021.12.14-ны өдрийн 601 дугаар тогтоолоор үл хөдлөх хөрөнгөнд бүртгэх шийдвэр гаргасан бөгөөд энэ шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй.	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	3,237,817.5	-	-	-	-	1	3,237,817.5	-	-	-
2	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	АХГ-2022/37/НА-СТА-ТӨА	Сумдын өгөгдлийн сүлжээний өргөтгөлийн төхөөрөмж нийлүүлэх” МХС/202101012 тоот тендерээр худалдан авсан 311.0 сая төгрөгийн үнэ бүхий 110 ширхэг тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг буруу /алдаатай/ гаргаснаас нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийн ажиллагааг дахин тохируулсан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	311,038.7	-	-	-	-	1	311,038.7	-	-	-
3	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК	АХГ-2022/37/НА-СТА-ТӨА	“Сервер болон хадгалах төхөөрөмж нилүүлэх” МХС/202101010 тоот тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй тендерийн хүчинтэй хугацаа дууссаны дараа гэрээ байгуулсан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	325,941.0	-	-	-	-	1	325,941.0	-	-	-
ДҮН					3	3,874,797.2	-	-	-	-	3	3,874,797.2	-	-	-
НИЙТ ДҮН					8	3,924,039.2	-	-	1	650.0	3	3,874,797.2	-	-	4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 68/АУС0054
АХГ-2022/37/МА-СТА-ТӨА
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Хөргөлтийн тоног төхөөрөмж нийлүүлэх” МХС/202101025 тоот тендерт шалгарсан Синус Дочи ХХК-ийн тендерт ирүүлсэн үнийн санал нь арифметик алдаатай бөгөөд зөрүү нь 650,000.00 төгрөг байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.1 “тендерийн үнэд арифметик алдаа болон орхигдуулсан жижиг хэмжээний зөрүүг залруулах, үнийн хөнгөлөлтийг харгалзан тендерийн үнийг бууруулах, захиалагч энэ хуульд заасныг үндэслэн үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтийг сонгосон бол тэдгээрт харгалзах саналуудыг мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэ дээр харгалзан тооцож тендерийн харьцуулах үнийг тодорхойлно,” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3- заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тендерт шалгарсан Синус Дочи ХХК-ийн тендерт ирүүлсэн үнийн санал нь Арифметик алдаатай бөгөөд зөрүү 650,000.00 (Зургаан зуун тавин мянган) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Энхтайван нарт хариуцуулав.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:



Д.ЗХБАЯР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264250

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akr\2022\0315 Auditin 4 Gazar-4.Docx

001090203



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 377/АО/СОД 54
АХГ-2022/37/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Сумдын өгөгдлийн сүлжээний өргөтгөлийн төхөөрөмж нийлүүлэх МХС/202101012 тоот тендерээр худалдан авсан 311,038,728.00 төгрөгийн үнэ бүхий 110 ширхэг тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг буруу /алдаатай/ гаргаснаас нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийн ажиллагааг дахин тохируулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 “Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.”, 46 дугаар зүйлийн 46.1.4 “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;”, 46.1.6 “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;” 47 дугаар зүйлийн 47.2.1 “техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, гарсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Энхтайван нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Г. ГҮНЖИДМАА

Д.ЭХБАЯР

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

\\10.10.10.20\Bishug_Khureg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-45.Docx

00108C1073



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 378/А0150054

Улаанбаатар хот

АХГ- 2022/37/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Сервер болон хадгалах төхөөрөмж нийлүүлэх” МХС/202101010 тоот тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй тендерийн хүчинтэй хугацаа дууссаны дараа 325,941,000.00 төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 “Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 30 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна.” 29 дүгээр зүйлийн 29.2 “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.” 29.4-т “Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах боломжгүй болсон бол захиалагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган, зөвшөөрөл авсны үндсэн дээр уг хугацааг нэг удаа 15 хоноггоор сунгаж болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, гарсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Энхтайван нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Г. ГҮНЖИДМАА

Д.ЭХБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 379/20150054
АХГ-2022/37/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 6,812,676,300.00 төгрөгийн 256 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 1,444,000,000.00 төгрөгийн ажил, үйлчилгээний 1 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1,793,817,552.00 төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; " 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, гарсан алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Энхтайван нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Г. ГҮНЖИДМАА

Д.ЭХБАЯР

